

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/85/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: В.Эрдэнэцогт Утас: 261885 Цахим хаяг:erdenetsogtv@audit.mn Аудитор: Б.Отгонцэцэг Утас: 261628 Цахим хаяг: otgontsetsegb@audit.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн Захирал: Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ.....	2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	9
4. АУДИТЫН ТАЙЛАН	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага	19
5.2 Зөвлөмж.....	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХБ	Азийн Хөгжлийн Банк
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ НЭГДСЭН
ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ НЭГЖИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Н.ЭРДЭНЭХҮҮ ТАНАА

2026.04.10 № 06/1053
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Азийн хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шат төсөл нь эмзэг бүлгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатны тусламж үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулж, улсын хэмжээнд иргэдээс гарах эрүүл мэндийн зардлыг бууруулахад чиглэсэн байна. Энэхүү хөрөнгө оруулалтын олон шатлалт хөтөлбөрийн нийт санхүүжилт 163.5 сая ам.доллар бөгөөд 2019-2029 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжих ба 1 дүгээр үе шатны төсөл нь 2019–2026 онуудад хэрэгжинэ.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал гол нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлын санхүүгийн тайлангийн аудитын бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2025 онд нийт 91 ажил төлөвлөгдсөнөөс 73 ажил хэрэгжиж, 18 ажил нь 2026 онд шилжсэн бөгөөд төлөвлөгөөний биелэлт 88.1 хувьтай байна. Төслийн 1 дүгээр үе шатны ерөнхий төлөвлөгөөний үйл ажиллагааны хэрэгжилт 2025 оны жилийн эцсийн байдлаар 89.2 хувийн гүйцэтгэлтэй, санхүүгийн хувьд гэрээлсэн дүнгийн 58.4 сая ам. доллар буюу 73.3 хувийг, зээл буцалтгүй тусламжийн зарцуулалт 29.2 сая ам.доллар буюу 36.9 хувийг санхүүжүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Сангийн яам, Эрүүл мэндийн яам болон Азийн Хөгжлийн банк хамтран зөвшилцөж, дунд хугацааны үнэлгээний дүгнэлт дээр үндэслэн, төслийн хугацааг дахин 2027 оны 12 дугаар сарын 31 хүртэл сунгахаар шийдвэрлэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	22,122,459.25	10,398,976,033.49
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	20,018,459.25	1,220,814,711.99
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	20,018,459.25	1,220,814,711.99
31210	Төгрөг	19,420,189.12	55,538,905.04
31211	Төрийн сангийн харилцах	19,420,189.12	55,538,905.04
31220	Гадаад валют	598,270.13	1,165,275,806.95
31221	Төрийн сангийн харилцах	598,270.13	1,165,275,806.95
33	АВЛАГА	-	1,124,329,950.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	5,606,750.00
33500	Бусад авлага	-	1,118,723,200.00
34	УРЬДЧИЛГАА	2,104,000.00	8,053,831,371.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	39,325,278,165.32	57,712,932,590.24
39	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	39,325,278,165.32	57,712,932,590.24
39200	Биет хөрөнгө	39,325,039,831.95	57,712,914,256.83
39203	Авто-тээврийн хэрэгсэл	100,000,000.00	100,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(50,000,000.04)	(70,000,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	124,719,887.75	124,719,887.75
39206	Хуримтлагдсан элэгдэл	(96,377,051.00)	(120,505,325.44)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	44,958,151.78	44,958,151.78
39208	Хуримтлагдсан элэгдэл	(38,391,952.85)	(44,275,455.54)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	39,240,130,796.31	57,678,016,998.36
39300	Биет бус хөрөнгө	238,333.37	18,333.41
39301	Программ хангамж	1,100,000.00	1,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(861,666.63)	(1,081,666.59)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	39,347,400,624.57	68,111,908,623.73
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,820,517,978.78	6,540,050,454.75
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,820,517,978.78	6,540,050,454.75
41300	Өглөг	10,813,931.10	6,540,050,454.75
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	10,813,931.10	364,891.51
41360	Бусад өглөг	-	6,539,685,563.24
41361	Байгууллагад төлөх өглөг	-	6,327,927,205.83
41363	Татварын өглөг	-	211,758,357.41
41400	Урьдчилж орсон орлого	5,809,704,047.68	-

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	33,526,882,645.79	61,571,858,168.98
51	Засгийн газрын хувь оролцоо	33,526,882,645.79	61,571,858,168.98
51200	Хуримтлагдсан үр дүн	33,526,882,645.79	61,571,858,168.98
51210	Өмнөх үеийн үр дүн	(1,983,602,061.47)	38,981,707,454.51
51220	Тайлант үеийн үр дүн	35,510,484,707.26	22,590,150,714.47
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	39,347,400,624.57	68,111,908,623.73

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	41,631,450,870.14	45,241,543,109.41
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,553,450,870.14	45,241,543,109.41
120	Нийтлэг татварын бус орлого	40,861,426,807.29	45,147,793,109.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,858,416,807.29	45,142,593,109.41
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	40,858,416,807.29	45,142,593,109.41
120009	Бусад орлого	3,010,000.00	5,200,000.00
122	Тусламжийн орлого	692,024,062.85	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,000,000.00	93,750,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	78,000,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	78,000,000.00	93,750,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,123,673,967.40	3,982,852,022.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,123,673,967.40	3,982,852,022.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,123,673,967.40	3,958,074,499.81
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	718,450,055.30	748,356,632.85
210101	Үндсэн цалин	718,450,055.30	748,356,632.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	68,947,288.13	68,972,477.16
210201	Тэтгэврийн даатгалын зардал	68,947,288.13	68,972,477.16
2104	Хангамж, бараа материалын зардал	12,366,494.82	11,785,776.00
210401	Бичиг хэрэг	4,455,140.00	3,879,735.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,611,354.82	4,651,041.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,831,250.00	15,096,760.00
210604	Урсгал засвар	8,831,250.00	15,096,760.00
2107	Томилолт, зочны зардал	49,186,094.00	52,429,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,210,072,126.23	3,006,886,686.67
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,205,591,226.23	3,002,337,086.67

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,480,900.00	4,549,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	55,820,658.92	54,546,967.13
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,141,550.00	4,315,190.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	52,679,108.92	50,231,777.13
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	24,777,522.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	35,507,776,902.74	41,258,691,086.76
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,707,804.52	156,733,017.86
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,707,804.52	156,733,017.86
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	18,825,273,390.15
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	7,435,689.00
225012	Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалтай хөрөнгийн зардал	-	18,817,837,701.15
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	2,707,804.52	(18,668,540,372.29)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	35,510,484,707.26	22,590,150,714.47

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	41,321,187,138.17	807,823,379.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	41,243,187,138.17	807,823,379.75
120	Нийтлэг татварын бус орлого	41,243,187,138.17	5,200,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	41,240,177,138.17	-
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	41,240,177,138.17	-
120009	Бусад орлого	3,010,000.00	5,200,000.00
122	Тусламжийн орлого	-	802,623,379.75
12211	Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	93,750,000.00
122002	Хандив тусламж /гадаад/	-	708,873,379.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	78,000,000.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	78,000,000.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	78,000,000.00	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,082,826,307.45	2,344,911,178.22
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,082,826,307.45	2,344,911,178.22
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,082,826,307.45	2,320,133,655.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	710,261,284.24	750,085,546.23
210101	Үндсэн цалин	710,261,284.24	750,085,546.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	78,000,000.00	68,972,477.16
210201	Тэтгэврийн даатгалын зардал	78,000,000.00	68,972,477.16
2104	Хангамж, бараа материалын зардал	12,366,494.82	11,785,776.00

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр-1 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210401	Бичиг хэрэг	4,455,140.00	3,879,735.00
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,255,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,611,354.82	4,651,041.00
210604	Урсгал засвар	8,831,250.00	15,096,760.00
2107	Томилолт, зочны зардал	49,186,094.00	58,035,950.00
210702	Дотоод албан томилолт	49,186,094.00	58,035,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,221,039,634.39	1,408,557,932.57
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,216,558,734.39	1,404,008,332.57
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,480,900.00	4,549,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,141,550.00	7,599,213.42.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	24,777,522.84
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	24,777,522.84
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	38,238,360,830.72	(1,537,087,798.47)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	39,240,130,796.31	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(39,240,130,796.31)	-
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	2,707,804.52	21,449,494.69
1451	Засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	2,716,434,556.52
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	2,707,804.52	2,737,884,051.21
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(999,062,161.07)	1,200,796,252.74
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,019,080,620.32	20,018,459.25
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	20,018,459.25	1,220,814,711.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	(1,983,602,061.47)	(1,983,602,061.47)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	(1,983,602,061.47)	(1,983,602,061.47)
9	Тайлант үеийн үр дүн	35,510,484,707.26	35,510,484,707.26
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	33,526,882,645.79	33,526,882,645.79
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	5,454,824,808.72	5,454,824,808.72
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	38,981,707,454.51	38,981,707,454.51
19	Тайлант үеийн үр дүн	22,590,150,714.47	22,590,150,714.47
20	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	61,571,858,168.98	61,571,858,168.98

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	838,750,000.00	777,845,856.91	60,904,143.09	92.7
12	Татварын бус орлого	838,750,000.00	777,845,856.91	60,904,143.09	92.7
122	Тусламжийн орлого	838,750,000.00	777,845,856.91	60,904,143.09	92.7
122002	Хандив тусламж / гадаад/	745,000,000.00	708,873,379.75	36,126,620.25	95.1
122005	Төсвөөс санхүүжих	93,750,000.00	68,972,477.16	24,777,522.84	73.6
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	44,850,970,000.00	44,033,394,656.52	817,575,343.48	98.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,458,970,000.00	4,065,891,221.82	393,078,778.18	91.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,458,970,000.00	4,065,891,221.82	393,078,778.18	91.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	751,000,000.00	750,085,546.23	914,453.77	99.9
210101	Үндсэн цалин	751,000,000.00	750,085,546.23	914,453.77	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,750,000.00	68,972,477.16	24,777,522.84	73.6
210201	Тэтгэврийн даатгал	93,750,000.00	68,972,477.16	24,777,522.84	73.6
2104	Хангамж, бараа материалын зардал	13,420,000.00	11,785,776.00	1,634,224.00	87.8
210401	Бичиг хэрэг	4,800,000.00	3,879,735.00	920,265.00	80.8
210402	Тээвэр, шатахуун	3,300,000.00	3,255,000.00	45,000.00	98.6
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,320,000.00	4,651,041.00	668,959.00	87.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,100,000.00	15,096,760.00	3,240.00	100.0
2107	Томилот, зочны зардал	58,300,000.00	58,035,950.00	264,050.00	99.6
210702	Дотоод албан томилот	58,300,000.00	58,035,950.00	264,050.00	99.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,523,200,000.00	3,158,174,722.43	365,025,277.57	89.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,514,500,000.00	3,153,625,122.43	360,874,877.57	89.7
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	8,700,000.00	4,549,600.00	4,150,400.00	52.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,200,000.00	3,739,990.00	460,010.00	89.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	40,392,000,000.00	39,967,503,434.7	424,496,565.30	99.0
220001	Барилга байгууламж	29,187,000,000.00	28,781,940,298.48	405,059,701.52	98.6
222001	Тоног төхөөрөмж	11,205,000,000.00	11,185,563,136.22	19,436,863.78	99.8
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(44,012,220,000.00)	(43,255,548,799.61)	(756,671,200.39)	98.3
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	44,012,220,000.00	43,255,548,799.61	756,671,200.39	98.3

7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	(1,178,005,981.47)	1,178,005,981.47	-
72	ЗГ-ын зээл	44,012,220,000.00	44,433,554,781.08	(421,334,781.08)	100.9
722	Гадаад	44,012,220,000.00	44,433,554,781.08	(421,334,781.08)	100.9
7221	Төслийн зээл	44,012,220,000.00	44,433,554,781.08	(421,334,781.08)	100.9
322101	Шинээр авах	44,012,220,000.00	44,433,554,781.08	(421,334,781.08)	100.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	42,808,730.52	(42,808,730.52)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,220,814,711.99	(1,220,814,711.99)	-

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Азийн Хөгжлийн банкны санхүүгийн дэмжлэгтэй хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны төсөл нь Улаанбаатар хотын гэр хороолол, Ховд, Увс аймаг болон сонгогдсон сумуудын эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн анхан болон лавлагаа шатны үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, сайжруулах замаар салбарын өнгөрсөн болон одоо хийгдэж буй шинэчлэлийг бататгана. Түүнчлэн энэхүү төсөл нь эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог сайжруулж улсын хэмжээнд иргэдээс гарах эрүүл мэндийн зардлыг бууруулахад чиглэнэ. Энэхүү хөрөнгө оруулалтын олон шатлалт хөтөлбөрийн нийт санхүүжилт 163.5 сая ам.доллар бөгөөд 2019–2029 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжинэ.

АХБ-ны Төслийн дунд хугацааны үнэлгээний үеэр Сангийн яам, Эрүүл мэндийн яам болон Азийн хөгжлийн банктэй зөвшилцөн, төслийн дуусах хугацаа 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байсныг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл сунгасан.

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр төслийн 1 дүгээр үе шат нь 2019-2027 оны хооронд дараах зорилтуудыг баримталж ажиллана. Үүнд

- Эрүүл мэндийн анхан шатны тусламжийг бэхжүүлэх;
- Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламжийг сайжруулах;
- Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх;
- Төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагуудын худалдан авалт, санхүүгийн менежментийн чадавхыг бэхжүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдөж ажилладаг.

Журмын 2.1-т “Журмыг хэрэгжүүлэхэд Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай

хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно” гэж зааснаар үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд төслийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" шинээр баталсан.

Төслийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын үйл ажиллагааг зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны төслийн санхүүгийн үйл ажиллагаанд Эрүүл мэндийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл нь Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг “Гадаад зээл, тусламжийн бүртгэл”, Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрддөг байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 28,764,508.0 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	20,018.4	1,220,814.7	1,200,796.3
Авлага	-	1,124,329.9	1,124,329.9
Урьдчилж төлсөн төлбөр	2,104.0	8,053,831.4	8,051,727.4
Үндсэн хөрөнгө	39,325,278.2	57,712,932.6	18,387,654.4
Нийт хөрөнгө	39,347,400.6	68,111,908.6	28,764,508.0
Өр төлбөр	5,820,518.0	6,540,050.5	719,532.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	33,526,882.6	61,571,858.1	28,044,975.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	39,347,400.6	68,111,908.6	28,764,508.0

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,220,814.7 мянган төгрөгт хүрч, 1,200,796.3 мянган төгрөгөөр өссөн нь Азийн хөгжлийн банкны зээл болон тусламжийн эх үүсвэрээс 3,425,307.9 мянган төгрөг, улсын төсвийн санхүүжилтээс 93,750.0 мянган төгрөг, тендерийн баримт бичиг худалдсаны орлогоор 5,200.0 мянган төгрөг, валютын ханшийн зөрүүгийн олз 21,449.5 мянган төгрөгийн орлогыг тус тус бүрдүүлж, урсгал зардалд 2,344,911.2 мянган төгрөг зарцуулсан нь нөлөөлсөн.

Авлага дансны үлдэгдэл 1,124,329.9 мянган төгрөг болж нэмэгдсэн нь Эрүүл мэндийн төвүүдэд нийлүүлэх тоног төхөөрөмж, тавилга худалдан авахаар шилжүүлсэн 1,118,723.2 мянган төгрөг болон ажиллагсдаас авах 5,606.7 мянган төгрөгийн авлага бүртгэсэн нь нөлөөлсөн.

Урьдчилж төлсөн төлбөр дансны үлдэгдэл 8,053,831.4 мянган төгрөг болж 8,051,727.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь ХУД-ийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын урьдчилгаа төлбөр олгосон.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 57,712,932.6 мянган төгрөг болж, 18,387,654.4 мянган төгрөгөөр өссөн нь дуусаагүй барилга байгууламж 45,304,555.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 12 дугаар сарын 26-ны 877 дугаар тогтоолоор төслийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж бий болсон 5,602,927.3 мянган төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн барилга байгууламж, 641,590.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн хамт Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын эрүүл мэндийн төвд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/373 дугаар тушаалаар Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт 11,206,085.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, А/374 дугаар тушаалаар Булган аймгийн Дашинчилэн сумын эрүүл мэндийн төвд 655,512.0 мянган төгрөг, Хөвсгөл аймгийн Тариалан сумын эрүүл мэндийн төвд 696,974.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлснээр, нийтдээ 18,803,089 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлж, ХУД-ийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын урьдчилгаа төлбөрийг алдаатай бүртгэснийг залруулж, 50,231.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон.

Өр төлбөр дансны үлдэгдэл 6,540,050.5 мянган төгрөг болж 719,532.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь 6,327,927.2 мянган төгрөгийн гэрээний дагуу суутгаж авсан барьцаа төлбөр болон гэрээт ажлын төлбөр, 212,123.3 мянган төгрөгийн татварын өр төлбөр нөлөөлсөн байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 28,044,975.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүн болон өмнөх тайлант үеүдэд гадаад зээлийн

хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, урьдчилж орсон орлогоор бүртгэсэн залруулга орсон нь нөлөөлжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг гадаад зээлийн 58,779,150.0 мянган төгрөг, буцалтгүй тусламжийн 340,500.0 мянган төгрөг, улсын төсвөөс санхүүжих 93,750.0 мянган төгрөг, нийт 59,213,400.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж урсгал зардалд 6,096,350.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 53,117,050.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж, батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 14,362,430.0 мянган төгрөгөөр бууруулж тодотгосон байна. Төсвийн захирагч Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн 4 зорилтын 15 хөтөлбөр арга хэмжээг санхүүжүүлэхээр гадаадын эх үүсвэрээс 44,757,220.0 мянган төгрөг, улсын төсвөөс 93,750.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр гадаадын эх үүсвэрээс 45,142,428.2 мянган төгрөг, улсын төсвөөс 68,972.5 мянган төгрөг, нийт 45,211,400.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна.

Тайлант онд төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,033,394.7 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна. Үүнээс цалин, НДШ-ийн зардалд 819,058.0 мянган төгрөг, хангамжийн зардалд 11,785.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 15,096.8 мянган төгрөг, томилолтын зардалд 58,036.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнд 3,158,174.7 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 3,740.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 39,967,503.4 мянган төгрөгийг тус тус зарцуулсан.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр	44,850,970.0	44,033,394.6	817,575.4	98.2
2	Үйл ажиллагааны зардал	4,458,970.0	4,065,891.2	393,078.8	91.2
3	Хөрөнгийн зардал	40,392,000.0	39,967,503.4	424,496.6	99.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 4 зорилт бүхий 15 үр дүнгийн 93 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

Зорилтууд	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжлтийн хувь	/мянган төгрөгөөр/ 2025 онд		
				Зарцуулах төсөв	Зарцуулсан	Хувь
1-р зорилт- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг бэхжүүлэх	2019-2026	Үр дүн 1: Үйлчлүүлэгчдэд ээлтэй 4 өрхийн эрүүл мэнд (ӨЭМТ)-ийн төвийг шинээр барьж, ашиглалтад оруулах	86.7	30,013,856.5	29,425,436.9	98.0
		Үр дүн 2: Үйлчлүүлэгчдэд ээлтэй 5 сумын эрүүл мэндийн төвийг шинээр барьж, ашиглалтад оруулах	93.3			
		Үр дүн 3: Анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг интеграцилах загварчлалыг турших	97.2			
		Үр дүн 4: Үндэсний түргэн тусламжийн тогтолцоог бий болгох	82.9			
		Үр дүн 5: Байгальд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах технологи нэвтрүүлэх (LCT)	20.0			
2-р зорилт: Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах,	2019-2026	Үр дүн 1: Хан-Уул дүүрэгт шинэ нэгдсэн эмнэлэг (ХУДНЭ)-ийг ашиглалтад оруулах	50	13,544,533.5	13,340,474.3	98.0
		Үр дүн 2: Ховд БОЭТ-ийн шинэ өргөтгөлийг ашиглалтад оруулах /2-р үе шат руу шилжсэн/	-			
		Үр дүн 3: Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн шинэ өргөтгөлийг ашиглалтад оруулах	100			
		Үр дүн 4: Бие даасан эмнэлгийн удирдлагын тогтолцоог бүрдүүлж бие даасан эмнэлгийн үйл ажиллагааг 3 эмнэлэгт хэрэгжүүлэх	97.5			
		Үр дүн 5: ХУДНЭ-г байгальд ээлтэй, нүүрсхүчлийн хий бага ялгаруулах технологи (LCT) суурилуулах	20.0			
3-р зорилт: Эрүүл мэндийн санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх	2019-2026	Үр дүн 1: Стратегийн худалдан авалтын зарчим, замыг тодорхойлох, төсвийн санхүүжилтийг ЭМД-ын санд шилжүүлэх	95.0	335,860.0	330,800.0	98.0
		Үр дүн 2: Хүйсээр ангилсан мэдээллийг эрүүл мэндийн санхүүжилтийн загварт нэвтрүүлэх	90.0			
		Үр дүн 3: ЭМД-ын Стратегийн худалдан авалтын чадавхыг бэхжүүлэх	95.0			

Дээрх зорилтуудтай холбоотойгоор тайлант онд дараах ажлууд хийгдсэн байна. Үүнд:

1 дүгээр зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна.

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг сайжруулах олон улсын зөвлөх фирм (CS01) гэрээний дагуу 15 техникийн тайлангуудыг Эрүүл мэндийн яам хянаж, хүлээн авснаар гэрээг дүгнэсэн байна.
- Түргэн тусламжийн тогтолцоог бэхжүүлэх олон улсын зөвлөх фирм (CS02) гэрээний дагуу 10 техникийн тайлангуудыг Эрүүл мэндийн яам хянаж, хүлээн авснаар гэрээг дүгнэх шатанд явагдаж байна.
- Өвөрхангай аймгийн Баян-Өндөр болон Булган аймгийн Дашинчилэн сумдын эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг бүрэн дуусган, улсын комисст хүлээлгэн өгч, ашиглалтад бүрэн оруулсан байна.
- Хөвсгөл аймгийн Тариалан сум, Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн 26 дугаар хорооны өрхийн эрүүл мэндийн төвийн барилгуудыг улсын комисс ажиллуулахад бэлэн болгосон байна.
- Дорноговь аймгийн Эрдэнэ сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажил 93.0 хувийн гүйцэтгэлтэй, үргэлжилж байна.
- Орон нутаг хариуцсан гадна дэд бүтцийн ажлууд хийгдээгүйгээс Чингэлтэй дүүргийн 19-р хорооны, Баянзүрх дүүргийн 17 дугаар хорооны өрхийн Эрүүл мэндийн төвийн барилгын ажлууд 55.0-77.0 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд барилгын норм, дүрмийн дагуу өвлийн улиралд түр зогсоосон байна.
- Өрх, сумын эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмж, тавилга нийлүүлэлтийн ажлын явц 95 хувь, нийлүүлэх 61 нэр төрлийн 461 ширхэг тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалт 3 сумын эрүүл мэндийн төвд амжилттай хийгдсэн, 3 өрхийн эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж ЭМЯ-ны харьяа Зоонозын өвчин судлалын үндэсний төвийн агуулахад хадгалагдсан, барилгын ажил дуусмагц суурилуулах ажил хийгдсэн байна.
- Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Хан-уул дүүргийн 14 дүгээр хорооны өрхийн Эрүүл мэндийн төвийн барилгад “Байгальд ээлтэй, нүүрстөрөгч бага ялгаруулах технологийг суурилуулах” барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг 3 удаа зохион байгуулсан боловч амжилтгүй болсон тул тоног төхөөрөмж суурилуулах, магадлан итгэмжлэлийн зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтууд хойшлогдсон байна.
- Түргэн тусламжийн үндэсний төвийн барилгын ажлын тендерийг зарлаж, үнэлгээ хийгдэж гэрээ байгуулан, Эрүүл мэндийн яамаар албажуулах шатандаа байна.

2 дугаар зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна.

- Төслийн бодлогын даалгаврын хүрээнд CS04 лавлагаа шатлалын эмнэлгийн удирдлагыг бэхжүүлэх, засаглалыг сайжруулах олон улсын зөвлөх фирм гэрээний дагуу 13 техникийн тайлангуудыг хүлээлгэн өгч, Эрүүл мэндийн яам хянаж хүлээн авснаар гэрээ дүгнэх шатанд явагдаж байна.
- Хан-Уул дүүргийн Нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажил 40 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд өвлийн улирал эхэлсэн тул түр зогссон байна.
- Увс аймгийн Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын ажлыг бүрэн дуусган, улсын комисст хүлээлгэн өгч, тоног төхөөрөмжийг угсарч суурилуулан ашиглалтад оруулсан байна.

3 дугаар зорилтын хүрээнд дараах ажлууд хийгдсэн байна.

- Эрүүл мэндийн тогтолцооны (CS29), санхүүжилтийн (CS33), багцын (CS30), өртөг төлбөрийн аргын (CS32), чанарын хяналт үнэлгээний (CS31) 5.0 хувь зөвлөхүүд 4

техникийн болон улирлын явцын 6 тайланг Эрүүл мэндийн яаманд хүлээлгэн өгсөн байна.

- Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн “Гэрээний үлгэрчилсэн загвар, гэрээний гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, аргачлал батлах” тогтоолын төслийг батлуулахаар ЭМДЕГ-т хүргүүлсэн байна.
- Эрүүл мэндийн яамны Эрүүл мэндийн даатгалын бодлого зохицуулалтын газраас Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын алба, төслийн багийн хамтарсан уулзалт (9/2), Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд оруулах өөрчлөлтийн хэлэлцүүлгийг цуврал байдлаар 10 дугаар сард зохион байгуулж эхэлсэн. Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн даатгалын хуулийн өөрчлөлтийн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

ТУХ-ны 2025 оны 2 дугаар сарын 10-ны өдрийн 1 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 32,258,996.6 мянган төгрөгөөр баталсан. Уг тогтоолоор 13 худалдан авалт төлөвлөснөөс 5 худалдан авалтын зарлагдсан тендерүүд амжилтгүй болж гүйцэтгэгч сонгон шалгараагүй, 5 худалдан авалт нь 2026 онд шилжиж, 3 худалдан авалт амжилттай зохион байгуулагдаж, 1 Түргэн тусламжийн үндэсний төвийн барилга угсралтын ажил гүйцэтгэх олон улсын нээлттэй тендерт шалгарсан Централ Азия Девелопмент ХХК-тай гэрээг 2026 оны 2 дугаар сард байгуулсан байна.

Тайлант хугацаанд худалдан авах төлөвлөгөөний дагуу дараах 2 гэрээг байгуулан ажилласан байна. Үүнд:

- Увс аймгийн нэгдсэн эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр 3 багц болон зарлагдсан олон улсын нээлттэй тендерт Космостек монгол ХХК болон Weigao Medical International компанийн түншлэл, Сетунари ХХК, Медимпекс интернэшнл ХХК шалгарч, нийтдээ 11,205,179 мянган төгрөгийн гэрээг 2025 оны 7 дугаар сард байгуулан ажилласан байна.
- Төсөл хэрэгжүүлэх нэгжийн байрны харуул хамгаалалтын ажил үйлчилгээг харьцуулалтын аргаар худалдан авч, Бумбат зүрх ХХК-тай, 2025 оны 5 дугаар сараас гэрээ байгуулан ажиллаж байна.

3.5.5 Судалгаа

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас 6 төрлийн судалгаа авч үр дүнг тайланд тусгалаа. Үүнд:

- Тус төслийн орон тоог 13 ажилтантай баталснаас тайлант онд 13 орон тоотой ажиллаж, 750,085.5 мянган төгрөгийн цалингийн зардал гаргаж, 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Эмч нарын VII хурал, эрүүл мэндийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн, багийн эмч нарын зөвлөгөөн зэрэг сургалт, арга хэмжээний зардал болох 50,000 мянган төгрөгийг зарцуулсан.
- Төслийн үйл ажиллагаандаа нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан гаргахад зориулагдсан Санхүүгийн тооцоолох групп ХХК-ийн 1,100.0 мянган төгрөгийн үнэтэй, Acolous санхүүгийн программ хангамжийг ашиглаж байна.

- Тус төслийн албан хаагчдад хоол, унааны мөнгө олгоогүй, гадаад томилолтын зардал, төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай гэрээ хийгдээгүй, төлбөр гараагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор М.Болормаа, аудиторын туслах Т.Аажингоо, Г.Халиун нар гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Л.Номин, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудитор Б.Отгонцэцэг, аудитын менежер В.Эрдэнэцогт, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2026 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 33 дугаар албан бичгээр төслөөс ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шат төсөл нь 2025 онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотойгоор мэдээлэл технологи, шуудан холбооны зардлыг 4,819.4 мянган төгрөг, бичиг хэргийн зардлыг 920.3 мянган төгрөгөөр, нийт 5,739.7 мянган төгрөгөөр зардлыг хэмнэсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49,838,578.2 мянган төгрөгийн 12 мэдээлэл байршуулахаас цаг хугацаандаа, бүрэн мэдээлсэн байна.

Энэ нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 дүгээр үе шатны төслийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,539,136.2 мянган төгрөгийн зөрчил илэрч, түүнд холбогдуулан 1 зөвлөмж, 4 албан шаардлага өгсөн байна. Үүнээс 2 албан шаардлага Төсөл хэрэгжүүлэх байгууллага эдгээр зөвлөмж, албан шаардлагыг биелүүлж ажилласан бөгөөд зөрчил арилгаж, санхүүгийн тайлагналын ил тод байдлыг хангасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	4	1,184,956.4	4	1,184,956.4	100.0
Зөвлөмж	1	1,354,179.8	1	1,354,179.8	100.0
Нийт дүн	5	2,539,136.2	5	2,539,136.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудлыг дараагийн аудитаар авч үзэхээр шийдвэрлэсэн. Үүнд:

Дараагийн аудитаар төслийн худалдан авах ажиллагааны дагуу хийгдсэн барилгын ажил, нийлүүлсэн тоног төхөөрөмжийг эрх бүхий байгууллагын тогтоол, шийдвэрийн дагуу хүрэх цэгт шилжүүлсэн эсэх, нягтлан бодох бүртгэлд хэрхэн тусгасан эсэхэд аудитын нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн төслийн үйл ажиллагааны хүрээнд бий болсон эмнэлгийн барилгуудад гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт, чанарын болон үр дүнгийн үзүүлэлтүүдэд гүйцэтгэлийн аудит оруулах саналтай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 21,740,664.6 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад алдааг бүрэн залрууллаа. Үүнд:

- Гадаад зээл тусламжаар хүлээн авсан мөнгөн хөрөнгөнөөс банкны үйлчилгээний хураамж суутгагдаж, тухайн байгууллагын дансанд орж ирдэг бөгөөд 265.1 мянган төгрөгийн хураамжийг мөнгөн гүйлгээний тайланд орлого, зарлагаар бүртгэж, буруу тайлагнасан байна.
- 2020-2024 онуудад АХБ-ны 5,809,704.0 мянган төгрөгийн гадаад зээлийн хөрөнгийг орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, урьдчилж орсон орлогоор бүртгэсэн байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангилалд 2023-2024 онд үүссэн татварын өрийг төлсөн 223,455.4 мянган төгрөгийг бүртгэснээр тайлант хугацааны зардлыг өсгөсөн байна. Мөн тайлант хугацаанд зөвлөх үйлчилгээ үзүүлсэн гадаадын ААНБ-аас 73,353.5 мянган төгрөгийн татвар суутгасан ч холбогдох зардлыг бүртгээгүй байна.
- Гүйцэтгэгч байгууллагын барилгын ажлын санхүүжилтээс гэрээний дагуу 5.0 хувийн барьцаа суутгаж авдаг бөгөөд ажлын санхүүжилтээс суутгасан 2,910,998.6 мянган төгрөгийн барьцаа хөрөнгийг бүртгээгүй байна. Мөн тайлант хугацаанд нийлүүлсэн тоног төхөөрөмжийн олгоогүй төлбөр 3,416,928.6 мянган төгрөгийн өр төлбөрийг бүртгэлд тусгаагүй байна.
- Тоног төхөөрөмж нийлүүлэх Интерсайнс ХХК болон ХУД-ийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэгч Чайна рейлвэй ферст групп компанид гэрээний дагуу 2024-2025 онуудад олгосон 9,167,554.6 мянган төгрөгийн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгээгүй, дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.
- Өмнөх оноос үргэлжилсэн 138,404.8 мянган төгрөгийн татварын өр төлбөрийн үлдэгдлийг бүртгээгүй байна.

Аудитаар 2 зөрчил² илэрсэнд 1 албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 2 зөрчил нь санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг хэмжээний зөрчил илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

Тус төсөл нь 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд тодруулгын хамт иж бүрэн толилуулаагүй, хугацаа хоцроосон, мөн өр төлбөр, урьдчилж орсон орлого, татварын зардлыг буруу бүртгэж тайлагнасан, и баримтгүй худалдан авалтыг зардлаар бүртгэсэн, өр төлбөр, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зэргээс санхүүгийн тайланд 21,640,664.7 мянган төгрөгийн залруулга хийгдэж байгаа нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Төсвийн тухай хуулийн 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж..." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4-д "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэсэн заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, иж бүрэн тайлагнах, бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгч байгууллагатай үүссэн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдэл болон нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг үнэн зөв хийж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.

5.2 Зөвлөмж

1. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Төслийн нэгжийн ажилтнуудын цалин хөлсийг НД-ын байгууллагад тайлагнахдаа даатгуулагчийн төрлийн кодыг 01001 кодоор тайлагнасан байна. Эдгээр ажилтнууд нь хөлсөөр ажиллах гэрээтэй бөгөөд Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-ын 2.2.6-т "тайланд даатгуулагчийн төрөл, цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын хэмжээ, улсын кодыг үнэн зөв оруулсан байх", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/44/А/40 дүгээр хамтарсан тушаал "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал"-д ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх 02001 даатгуулагчийн төрөл, код нь Иргэний хуульд заасан ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах болон бусад гэрээгээр ажиллагч байна" гэсэнтэй нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төслийн нэгжийн ажилтнуудын цалин хөлсийг зөв кодоор тайлагнаж, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөөр орж ирээгүй ажил гүйлгээг МГТ-д тусгасан.	1	265.1			1	265.1	1	265.1		
АХБ-наас орж ирсэн гадаад эх үүсвэрийг орлогоор бүртгээгүй.	1	5,809,704.0			1	5,809,704.0	1	5,809,704.0		
Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс зардлын ангилалд төлсөн татварыг бүртгэсэн. Мөн БГАХ дутуу бүртгэсэн.	1	296,808.9			1	296,808.9	1	296,808.9		
Гүйцэтгэгчээс суутгасан барьцаа болон олгоогүй санхүүжилтийг бүртгээгүй.	1	15,495,481.8	1	15,495,481.8			1	15,495,481.8		
Татварын өр төлбөрийн үлдэгдлийг бүртгээгүй	1	138,404.8	1	138,404.8			1	138,404.8		
Дүн	5	21,740,664.6	2	15,633,886.6	3	6,106,778.0	5	21,740,664.6		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд тодруулгын хамт иж бүрэн толилуулаагүй, хугацаа хоцроосон, мөн өр төлбөр, урьдчилж орсон орлого, татварын зардлыг буруу бүртгэж тайлагнасан, и баримтгүй худалдан авалт, зардал гарсан зэрэг санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.	1	-			1	-							
Хөлсөөр ажиллах гэрээтэй ажилтнуудын даатгуулагчийн төрлийн кодыг буруу тайлагнасан.	1	-					1	-					
Дүн	2	-			1	-	1	-					



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1259/АД150185

Улаанбаатар хот

САГ-2026/85/КА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр 1 төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд тодруулгын хамт иж бүрэн толилуулаагүй, хугацаа хоцроосон, мөн өр төлбөр, урьдчилж орсон орлого, татварын зардлыг буруу бүртгэж тайлагнасан, өр төлбөр, урьдчилж орсон орлогын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулдаггүй зэргээс санхүүгийн тайланд 21,740,664,740.00 /хорин нэгэн тэрбум долоон зуун дөчин сая зургаан зуун жаран дөрвөн мянга долоон зуун дөчин/ төгрөгийн залруулга хийгдэж байгаа нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байгаагаас шалтгаалж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 5.1.5-д "хариуцлагатай байх" 8.9.1 "төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж..." Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтөлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй", 4.2.1.7-д "авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүүгийн тайланг хуулийн хугацаанд, иж бүрэн тайлагнах, бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгч байгууллагатай үүссэн авлага, өглөгийн тооцоог тооцоо нийлсэн актаар бүрэн баталгаажуулах, анхан шатны баримтын бүрдэл болон нягтлан бодох бүртгэлийн дансны бичилтийг үнэн зөв хийж, санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж ажиллах, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Эрүүл мэндийн яамны нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Н.Эрдэнэхүү, санхүүгийн мэргэжилтэн Г.Тунгалагтамир нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН
САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:
БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
В.ЭРДЭНЭЦОГТ
Ц.ЖИГДЭН

